# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 09 өдөр Дугаар А/114 Улаанбаатар хот

## Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын Ой тэмдэглэх тухай 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар захирамж, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах төсөв батлуулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Ажлын хэсэг (Б.Энхболд)-т даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/57 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА А.ЭНХМАНЛАЙ

9128921 9024019026

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
152401048 9
ЭХ ХУВЬ
Захиргааны акт нэр тушаал
дугаар А/114

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн А/114 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга |
| АЖЛЫН ХЭСГИЙН ОРЛОГЧ ДАРГА: | Газрын судалгаа шинжилгээ, бодлого төлөвлөлтийн газрын дарга |
| НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: | Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга |
| | Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газрын дарга |
| ГИШҮҮД: | Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга |
| | Кадастрын хэлтсийн дарга |
| | Газрын биржийн хэлтсийн дарга |
| | Газрын мониторингийн хэлтсийн дарга |
| | Геодези, зураг зүйн хэлтсийн дарга |
| | Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга |
| | Хуулийн хэлтсийн дарга |
| | Салбарын архивын хэлтсийн дарга |
| | Салбарын хяналт шалгалтын хэлтсийн дарга |
| | Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга |
| | Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга |
| | Монголын Газар зохион байгуулагчдын холбоо ТББ-ын тэргүүн |
| | Монголын Газрын менежментийн нэгдсэн эвсэл ТББ-ын тэргүүн |
| | Монголын Газрын менежментийн чөлөөт холбоо ТББ-ын тэргүүн |
| | Монголын кадастрын холбоо ТББ-ын тэргүүн |
| | Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо ТББ-ын тэргүүн |
| | Монголын гео мэдээллийн холбоо ТББ-ын тэргүүн |
| | Ахмадын зөвлөлийн дарга |

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 09 -ны өдрийн А/114 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 70 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Арга хэмжээ | Хугацаа | | Хариуцах байгууллага | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн | Хамтрагч | |
| 1. | Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тохиолдуулан хэрэгжүүлэх “70 бүтээлч ажил” ажлыг зохион байгуулах | I-XII сар | Жилдээ | ГЗБГЗЗЕГ-ын ОЗӨДБГ | ГЗБГЗЗЕГ-ын ГСШБТГ, 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА | Салбарын хэмжээнд 70 бүтээлч ажил ойн арга хэмжээг тохиолдуулан хэрэгжүүлнэ. Шаардлагатай зардлын тооцоог гаргаж батлуулна. |
| 2. | Газрын харилцааны салбарыг сурталчилсан ТВ-ийн нэвтрүүлэгт оролцох ажлыг зохион байгуулах | I-XII сар | Жилдээ | ГЗБГЗЗЕГ-ын ТЗУГ | ГЗБГЗЗЕГ-ын ГСШБТГ | ТВ-үүдийн нэвтрүүлэгт оролцох төлөвлөгөөг гаргаж, шаардлагатай зардлын тооцоог гаргаж батлуулна. |
| 3. | Салбартаа амжилт гаргаж, үр бүтээлтэй ажилласан ажилтан, албан хаагчдыг шагналд тодорхойлох ажлыг зохион байгуулах | III сар | 3 сар | ГЗБГЗЗЕГ-ын ТЗУГ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, Мэргэжлийн холбоод | Мэргэжлийн холбоод, 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА-нд мэдээлэл хүргэж шагналд тодорхойлох хүмүүсийн материалыг авч холбогдох газарт хүргүүлнэ. |
| 4. | Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах бүсчилсэн хөгжил, орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд сэдэвт салбар дундын хурлыг зохион байгуулах | | 3 сар | ГЗБГЗЗЕГ-ын ГЗБХ | ЭЗХЯ, ШУА-ын ГГХ, МУИС, ХААИС | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5. | Газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах журмуудыг шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулах. Үүнд:<br>- Газар зохион байгуулалт хийх журам;<br>- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам;<br>- Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам;<br>- ГНСУНЦС-ийн журам;<br>- Нийтийн сервитут тогтоосон газарт нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцож олгох журам. | III-V сар | 3-5 сар | ГЗБГЗЗЕГ-ын ТЗУГ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд | |
| 6. | Их, дээд сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | IV сар | 4 сар | ГЗБГЗЗЕГ-ын ГСШБТГ, КХ, МГЗБХ | МУИС,<br>ХААИС,<br>ЭШХүрээлэн,<br>“Наранцацралт сан” ТББ | Эрдэм шинжилгээний хурал, олимпиадын шагналд өгөх ном, атласын тоог гаргаж зардлын тушаал батлуулна.<br>Зохион байгуулалтыг их дээд сургуулиудтай хамтран хийнэ. |
| 7. | Геодези, зураг зүйн улсын олимпиад зохион байгуулах | | 4 сар | ГЗБГЗЗЕГ-ын ГЗЗХ | ШУТИС, ҮТИС, ХААИС | |
| 8. | Газрын харилцааны ажилтны өдрийн нэрэмжит “Шилжин явах цом”-ын спортын тэмцээн зохион байгуулах | | 4 сар | НГЗБА | МГЗБХ | - |
| 9. | Хамтын ажиллагаатай олон улсын байгууллага, улс орнуудын мэндчилгээг хүлээн авах, шторк бэлтгэх ажлыг зохион байгуулах | | 4 сар | ГЗБГЗЗЕГ-ын ТЗУГ | ГЗБГЗЗЕГ-ын МТХ МГЗБХ | Шторк бэлтгэх зардлын тооцоог гаргаж батлуулна. |
| 10. | Оюутан, сурагчдын дунд мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулах | | 4 сар | ГЗБГЗЗЕГ-ын СХШХ | ГЗБГЗЗЕГ-ын ГЗЗХ | Төлөвлөгөө гаргаж батлуулна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11. | Газрын харилцааны салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойн энгэрийн тэмдэг, ойн медаль, дурсгалын зүйл хийлгэх ажлыг зохион байгуулах | | 4 сар | МГЗБХ | ГЗБГЗЗЕГ-ын ХХ, СЭЗХ | Энгэрийн тэмдэг, ойн медаль, дурсгалын зүйл хийлгэх зардлын тооцоог гаргаж батлуулна. |
| 12. | “3D Кадастрын Дэлхийн Шилдэг туршлагууд” FIG-ийн албан ёсны эрхтэйгээр орчуулж, хэвлүүлэх | | 4 сар | Монголын Кадастрын Холбоо | ГЗБГЗЗЕГ | - |
| 13. | Газрын харилцааны судлаачдын дунд эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах | VI-V сар | 4 сар | МГЗБХ | ХААИС, ЭШХүрээлэн | - |
| 14. | Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн цогцолбор байгуулах ажлыг зохион байгуулах | IV-VII сар | 4-7 сар | МГЗБХ | ГЗБГЗЗЕГ | Хүндэтгэлийн цогцолбор байгуулах газрын байршил, зардлын тооцоог гаргана. |
| 15. | Газрын харилцааны салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойд зориулсан хүчит бөхийн барилдаан зохион байгуулах | V сар | 5 сар | МГЗБХ | ГЗБГЗЗЕГ | - |
| 16. | “Газрын харилцааны мэдээлэл” сэтгүүлийн 70 жилийн ойн баярын дугаар гаргах ажлыг зохион байгуулах | | 5 сар | ГЗБГЗЗЕГ-ын ГМХ | ГЗБГЗЗЕГ-ын ГСШБТГ | Хэвлэлийн зардлын тооцоог гаргаж батлуулна. |
| 17. | Газрын харилцааны хууль, дүрэм журмын цахим эмхэтгэл гаргах ажлыг зохион байгуулах | | 5 сар | ГЗБГЗЗЕГ-ын ХХ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, МГЗБХ | Эмхэтгэлийн загвар, зардлын тооцоог гаргаж батлуулна. |
| 18. | Тэрбум мод арга хэмжээний хүрээнд “Геодези, зураг зүйн төгөл”-д мод тарих ажлыг зохион байгуулах | | 5, 9 сар | ГФЗЗХ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, Мэргэжлийн холбоод | Зардлын тооцоо гаргаж батлуулах, мод тарих газрыг тодорхой болгоно. |
| 19. | Албан хаагчдын дунд явган аяллыг зохион байгуулах | | 5 сар | ГЗБГЗЗЕГ-ын ГБХ | ГЗБГЗЗЕГ-ын ХХ | Аялалын хөтөлбөр, зардлын тооцоог боловсруулж батлуулна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 20. | Салбарын албан хаагчдыг чадавхижуулах сургалтыг бүсчлэн зохион байгуулах | V-IX сар | 5-6 сар | ГЗБГЗЗЕГ, МГЗБХ | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, зардлын тооцоог гаргаж батлуулна. |
| 21. | Евроазийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн X хурлыг зохион байгуулах | IX сар | 9 сар | ГЗБГЗЗЕГ-ын ОЗӨДБГ | ГЗБГЗЗЕГ-ын МТХ, ГЗЗХ, Монголын Гео-мэдээллийн Холбоо | Ажлын хэсэг байгуулж зохион байгуулалтын асуудлыг хариуцна. |
| 22. | “Газар өмчлөл 20 жил” ном хэвлүүлэх | | 9 сар | Монголын Кадастрын Холбоо | ГЗБГЗЗЕГ | - |
| 23. | “Хариуцлагатай газрын харилцаа” жилийн хүрээнд иргэдэд чиглэсэн ажил танилцуулах өдөрлөг зохион байгуулах | | 9 сар | ГЗБГЗЗЕГ-ын КХ | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА | Ажил танилцуулах өдөрлөгийн төлөвлөгөө, шаардлагатай зардлын тооцоог батлуулна. |
| 24. | Салбарын түүх, бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийг харуулсан баримтат кино бүтээх ажлыг зохион байгуулах | | 9сар | МГЗБХ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, Мэргэжлийн холбоод | Ажлын хэсэг байгуулж киноны сэдэв, зохиолын төсөл, зардлын тооцоог гаргана. Баримтат кино хийх хуулийн этгээдийг тодорхой болгоно. |
| 25. | Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн товхимол хэвлүүлэх ажлыг зохион байгуулах /цаасан болон цахим/ | | 9 сар | ГЗБГЗЗЕГ-ын ГСШБТГ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, МГЗБХ | Зардлын тооцоо гаргаж батлуулна. Хэвлэлийн газартай гэрээ байгуулна. |
| 26. | Ахмадын өдрийг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах | X сар | 10 сар | ГЗБГЗЗЕГ-ын ТЗУГ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, Мэргэжлийн холбоод Ахмадын зөвлөл | |
| 27. | Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тохиолдуулан салбарын ахмадуудтай ярилцлага зохион байгуулж, сэтгүүлд нийтлэх | | 10 сар | ГЗБГЗЗЕГ-ын ТЗУГ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, Мэргэжлийн холбоод Ахмадын зөвлөл | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 28. | Салбарын ажилтнуудын дунд ажил мэргэжил, ур чадварын тэмцээн зохион байгуулах | XI сар | 11 сар | ГЗБГЗЗЕГ-ын ТЗУГ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА | - Газар зохион байгуулагч<br>- Газрын Кадастр<br>- Газрын төлбөр<br>- Газар өмчлөл<br>- Нягтлан бодогч нар |
| 29. | Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-ийн өдөр – 2024 /GISday/-г зохион байгуулах | | 11 сар | Монголын Геомэдээллийн Холбоо | ГЗБГЗЗЕГ, Дархан-ХААИС, МонМэп ХХК, Ухаалаг тариалан ТББ | 2024 оны 11-р сарын 20-нд Дархан-Уул аймгийн Дархан хотод Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-ийн өдөр – 2024 /GISday/-ийг hybrid /танхим, онлайн/ хэлбэрээр зохион байгуулна. |
| 30. | Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн баярын хурал, хүндэтгэлийн концертын арга хэмжээг зохион байгуулах | XII сар | 12 сар | ГЗБГЗЗЕГ-ын СЭЗХ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, МГЗБХ | Баярын хурал, хүндэтгэлийн концертын хөтөлбөр, зардлын тооцоог гаргаж батлуулна. |
| 31. | Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээг зохион байгуулах | | 12 сар | МГЗБХ | ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн удирдлагууд, Мэргэжлийн холбоод | Холбогдох зардлын тооцоог гаргаж батлуулна. |

--oOo--